



МОНГОЛ

МОНГОЛ
УНДЭСНИЙ
БИЧИГ
12-Р АНГИ
МХБУЗ-ЫН
БАГШ
Б.ЭНЭБИШ

*Монголчуудын
бичиг үсгийн
түүх*

— *Үндэсний бичиг, 12-р анги
МХБУЗ-ын багш Б.Энэбиш*


Монгол хэл нь монголчуудын соёл, сэтгэлгээний онцлогийг тусгасан хүн төрөлхтний хэлний нэгэн эд эс учраас монгол хүн бүр сурч эзэмших, хамгаалан хөгжүүлэх, хойч үедээ уламжлуулах журамт үүрэгтэй. Өнөөдөр амьд байгаа монгол хэл нь Төв Азийн нүүдэлчдийн жишиг болсон монголчуудын соёл иргэнишил, сэтгэлгээний дархлааг хадгалж тээж ирсэн баялаг түүхтэй, урт настай оюуны сан хөмрөг юм. Дэлхийн олон хэлний дотроос хэрэглэгчийн тоогоор харьцангуй цөөн (Албан бус мэдээгээр 6 сая гаруй монгол хэлтэн байдаг гэдэг) боловч мөхөх аюулаас хол, урт настай хэлний нэг бол монгол хэл. (Ц.Өнөрбаян “Чихинү чимэг болсон аялгуу сайхан Монгол хэл, Уб., 2018 он, 8-р тал)

Төв Ази дахь эртний төр улсууд, түүний дотор Монгол угсаа гаралтны дээдэс эрт Хүннүгийн үеэс өөрийн бичиг үсгийг шинээр зохиох буюу өмнөх үеийнхнийг уламжлан хэрэглэж байжээ. Тэдгээрээс хятанчуудын бичиг үсгийн дурсгал бидний үед уламжлан үлдсэн юм. Хятанчууд өөрийн Их Ляо улсаа байгуулан 920 онд Их бичиг, 925 онд Бага бичгээ зохиожээ. Хятан бичгийг өнөө болтол бүрэн тайлж уншаагүй байна. (Р.Нарангэрэл нар “Иргэний боловсрол Х, Уб., 2014 он, 92-р тал)

Монголчууд нүүдэлчдийн дотроос хамгийн олон бичиг хэрэглэсэн дорнын номт гурван улсын нэг. Монголын нэрт зохиолч Л.Түдэв “Монголчууд эрт үеэсээ эхлэн долоогоос найман бичиг үсэг зохион, билиг оюунаараа бүтээж ирсэн бөгөөд хэмүү, зангилаа, зурлага, татлага, гогцоо, тамга, угалзан, сийлбэр зэрэг дүрслэх урлагийн бүхий л аргаар үсэг бичиг зохиожээ” хэмээн дурдсан нь бий.

Уйгур

Эрдэмтдийн үзэж байгаагаар монголчууд анх XIII зуунаас өмнө Согд-Уйгураас гаралтай уйгар үсгийг авч хэрэглэжээ. Одоогийн хэрэглэж байгаа монгол бичгийн үүслийг энэ бичиг үсэгтэй холбоотой гэдгийг судлаачид хүлээн зөвшөөрдөг.



Дөрвөлжин бичиг

Дараа нь 1269 онд Юань улсын Хубилай (1215-1294) хааны зарлигаар Пагва лам Лодойжанцан дөрвөлжин бичиг зохиожээ. Энэ бичгийг хааны зарлиг, тамга тэмдэг, найз, гэрэгэ, цаасан мөнгө зэрэгт хэрэглэж байсан. Хубилай хаанаас хойш 80 орчим жил хэрэглэсэн мэдээ бий.



Али гали


Алтан хааны зарлигаар төвд хэлнээс орчуулсан “Ганжуур”-ыг монгол хэлнээ орчуулах явцад Харчины Аюуш гүүш 1587 онд “Али Гали” хэмээх галиг үсэг зохиосон нь самгард, төвд, хятад зэрэг харь хэлний үсгийг тэмдэглэх бүрэн боломжтой болгосон аж. Гэвч тэр нь монгол үндэсний бичгийг төлөөлж чадахуйц бие даасан бичиг бус, харин үсгийн бүрэлдэхүүнийг нэмэн баяжуулжээ.

GALIK.

Zeichen	Wert	Zeichen	Wert	Zeichen	Wert	Zeichen	Wert	Zeichen	Wert	Zeichen	Wert
ᠠ	a	ᠠᠤ	au	ᠭ	ga	ᠬ	lha	ᠮ	pa	ᠰ	sa
ᠡ	e	ᠡᠤ	ā	ᠭᠪ	gba	ᠬᠠ	da	ᠮᠪ	pha	ᠰᠠ	sa
ᠢ	i	ᠢᠤ	ai	ᠬᠠ	ha	ᠬᠠ	qha	ᠮᠪ	ha	ᠰᠠ	sa
ᠣ	o	ᠣᠤ	o, ri	ᠬᠢ	tā	ᠬᠢ	ya	ᠮᠪᠠ	lha	ᠰᠠ	sa
ᠤ	u	ᠤᠤ	u, ri	ᠬᠢ	tā	ᠬᠢ	ta	ᠮᠠ	ma	ᠰᠠ	ksa
ᠨ	n	ᠨᠤ	li	ᠬᠢ	dā	ᠬᠢ	lha	ᠮᠠ	ra	ᠰᠠ	Pause
ᠠ	e	ᠠᠤ	li	ᠬᠢ	dā	ᠬᠢ	da	ᠮᠠ	la	ᠰᠠ	Punkt
ᠠ	ai	ᠠᠤ	ka	ᠬᠢ	sa	ᠬᠢ	dha	ᠮᠠ	ya		
ᠠ	o	ᠠᠤ	kha	ᠬᠢ	ta	ᠬᠢ	na	ᠮᠠ	wa		

Тод бичиг

Ойрадын Зая бандида Намхайжамц (1599-1662) 1648 онд тод үсгийг зохиожээ. Энэ үеийн улс төр, нийгмийн байдлын хувьд монголчуудын тусгаар тогтнолд манжийн зүгээс заналхийлсэн, Монголчууд эв нэгдлийн хувьд тийм ч таатай цаг биш байжээ. Нэрт зохиолч, академич Бямбын Ринчен “Манжийн эрхшээлээс дөрвөн ойрадыг тусгаар улс болгон тэднийг өөр хооронд нь үсэг бичгийн талаар нэгтгэн холбохын үүднээс тод үсгийг зохиосон” гэж дурджээ. Тод үсгийг баруун ойрад, халимаг үндэстэн ихэвчлэн хэрэглэж байжээ.



Соёмбо үсэг



Энэтхэг төвдийн үсгээс уламжлан монголчуудын зохиосон бичгийн нэг бол ХҮИ зуунд зохиогдсон соёмбо үсэг юм. Соёмбо үсгийг бурхны шашин хүчтэй дэлгэрсэнтэй холбоотойгоор самгард, төвд хэлний нэр томьёо, ухагдахууныг бичгийн хэлэнд зөв тэмдэглэн бичих үүднээс Халхын өндөр гэгээн Занабазар (1635-1723) зохиосон байна. Соёмбо гэдэг нь “өөрөө бүтсэн гэгээн үсэг” гэсэн утгатай үг юм. Сүм хийдийн хүрээнд 200 гаруй жил явцуу хэрэглэсэн байна. Бурхан шашны сургаал, тамга тэмдэг, номын гарчиг, чимэглэлийн төдийгөөр хэтрэхгүй байгаа билээ.

Вагиндрагийн үсэг

Vagindra Script and Its Phonetic Value

Phonetic Value	a	o	i	u	ö	ü	o
Beginning	ᠠ	ᠡ	ᠢ	ᠣ	ᠤ	ᠥ	ᠦ
Termination	ᠠ᠊	ᠡ᠊	ᠢ᠊	ᠣ᠊	ᠤ᠊	ᠥ᠊	ᠦ᠊
Phonetic Value	h	kh	g	gh	ng	ch	chh
Beginning	ᠬ	ᠭ	ᠮ	ᠨ	ᠣ	ᠳ	ᠴ
Termination	ᠬ᠊	ᠭ᠊	ᠮ᠊	ᠨ᠊	ᠣ᠊	ᠳ᠊	ᠴ᠊
Phonetic Value	sh	h	kh	z	ch	chh	h
Beginning	ᠰ	ᠬ	ᠭ	ᠵ	ᠳ	ᠴ	ᠬ
Termination	ᠰ᠊	ᠬ᠊	ᠭ᠊	ᠵ᠊	ᠳ᠊	ᠴ᠊	ᠬ᠊

Монгол бичиг болон тод бичгийн хэлбэрээс санаа авч Буриадын Агваан хамба 1905 онд “Буриадын шинэ үсэг” буюу “Вагиндрагийн үсэг” зохиосон. Зохиосон үсгээ Агваан хэмээх өөрийн нэрээ самгард хэлээр хөрвүүлэн Вагиндра хэмээн нэрлэжээ. Үсгийн дуудлага бүрийг ялган тэмдэглэсэн бөгөөд орос хэлэнд тохируулж “ы, дж, дз, ц” зэрэг үсгийг нэмж зохиосон байна.

Латин, кирил



1930 оноос монгол бичгийг латин үсгээр солих оролдлого гарсан. Харин 1946 оноос одоог хүртэл кирилл бичгийг үндэсний монгол бичгийн хамт хослуулан хэрэглэж байна.

	Кирилл үсэг	Латин үсэг
1	Аа	Aa
2	Бб	Bb
3	Вв	Vv
4	Гг	Gg
5	Дд	Dd
6	Жж	Jj
7	Зз	Zz
8	Йй, Ии, Ы	Ii
9	Кк	Kk
10	Лл	Ll
11	Мм	Mm
12	Нн	Nn
13	Оо	Oo
14	Өө	Qq
15	Пп	Pp
16	Рр	Rr
17	Сс	Ss
18	Тт	Tt
19	Уу, Юю	Uu
20	Үү	Vv
21	Фф	Ff
22	Хх	Hh
23	Цц, Чч	Cc
24	Шш, Шш	Xx
25	Ээ, Ее, Ёё	Ee
26	Яя	Yy

Гэрийн даалгаварт

Монголчуудын бичиг үсгийн түүхэн хөгжлийн тойм

<i>Хэзээ зохиосон бэ</i>	<i>Хэн зохиосон бэ</i>	<i>Ямар үсэг зохиосон бэ</i>	<i>Онцлог нь юу вэ</i>
<i>XIII зуунаас өмнө</i>	<i>Согд Уйгураас гаралтай</i>	<i>Уйгур үсэг</i>	<i>Одоо хэрэглэж байгаа бичиг үсгийн үүсэл болсон</i>
<i>1269 онд</i>	<i>Пагва лам Лодойжанцан</i>	<i>Дөрвөлжин үсэг</i>	<i>Хааны зарлиг , тамга тэмдэг, пайз, гэрэгэ, цаасан мөнгөзэрэгт хэрэглэж байсан</i>
<i>1587 онд</i>	<i>Харчины Аюуш гүүш</i>	<i>Али гали үсэг</i>	<i>Харь хэлний үсгийг тэмдэглэх боломжтой болсон</i>
<i>1648 онд зохиосон</i>	<i>Зая Бандид Намхайжанцан</i>	<i>Тод үсэг</i>	<i>Баруун Монголчууд хэрэглэдэг байсан</i>
<i>1635-1723 онд</i>	<i>Өндөр гэгээн Занабазар</i>	<i>Соёмбо үсэг</i>	
<i>1905</i>			
		<i>Кирил үсэг</i>	

Монголчуудын бичиг үсгийн түүхэн хөгжлийн тойм

<i>Хэзээ зохиосон бэ</i>	<i>Хэн зохиосон бэ</i>	<i>Ямар үсэг зохиосон бэ</i>	<i>Онцлог нь юу вэ</i>
<i>XIII зуунаас өмнө</i>			<i>Одоо хэрэглэж байгаа бичиг үсгийн үүсэл болсон</i>
	<i>Пагва лам Лодойжанцан</i>		
		<i>Али гали үсэг</i>	<i>Харь хэлний үсгийг тэмдэглэх боломжтой болсон</i>
<i>1648 онд зохиосон</i>			<i>Баруун Монголчууд хэрэглэдэг байсан</i>
	<i>Өндөр гэгээн Занабазар</i>		
<i>1905</i>			
		<i>Кирил үсэг</i>	